



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ОНЦГОЙ КОМИСС

300 дугаар байр, Тээвэрчдийн гудамж 3,
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,

Баянхонгор аймаг, 64101

Утас:(976) 70443206,70442030, 70442883, 70440119

Цахим шуудан: munkhsaikhan@bayanhongor.gov.mn

Цахим хаяг:Bkh.nema.gov.mn

2024. 10. 09 № 50

танай _____ -ны № _____ -Т

Г

БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГА,
ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА О.МОНХБАТ ТАНАА

Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 112-т
заасны дагуу гамшигаас хамгаалах “Иж бүрэн” сургуулийг
2024 оны 10 дугаар сарын сүүлийн 10 хоногт багтаан зохион
байгуулахаар төлөвлөсөн тул сургууль, дадлагын бэлтгэл
ажил хангаж, хамтран ажиллана уу.

Хавсралтаар сургуулийн бэлтгэл ажил хангах
удирдамжийг хүргүүлэв.

Хавсралт ... хуудастай.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА

Б.МЯГМАРСҮРЭН

TTM0457-9007547

642212200



ГАМШГААС ХАМГААЛАХ “ИЖ БҮРЭН” СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ ХАНГАХ УДИРДАМЖ

Нэг. Сургуулийн зорилго

1.1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 17/59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 112 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны “Заавар батлах тухай” А/412 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар”, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд бүх шатны Засаг дарга, сумын Онцгой комиссын гишүүд, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, иргэд, аж ахуй нэгжүүдийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршигийг арилгах, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхэд татан оролцуулж, харилцан ажиллагааг сайжруулах, хүч хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлж, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. Зорилт

2.1. Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох, бодит байдалд нийцэж буйг шалгах (мэргэжлийн ангийн томилгоо, захирамж, төлөвлөгөөний боловсруулалт, судалгаа тооцоо, дайчилгааны төлөвлөгөөг бодит байдалд туршин шалгах үзүүлэх дадлага сургууль зохион байгуулах);

2.2. Сумын мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн болон төлөвлөсөн ажлын уялдаа холбоо харилцан ажиллагааг сайжруулах;

2.3. Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын албан тушаалтнуудыг гамшгийн үеийн үүрэгт ажилд сургаж, дадлагажуулах, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх;

2.4. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэхээр томилгоот хүч хэрэгслийн бэлэн байдлыг шалгаж үнэлэх (аврах, үзүүлэх дадлага сургууль зохион байгуулах, мэргэжлийн ангийн оролцоо, ур чадварыг дээшлүүлэх);

2.5. Гамшгийн үеийн холбоо зарлан мэдээллийн техник, багаж хэрэгслийн бэлэн байдлыг шалгаж үнэлэх;

2.6. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль, гамшгаас хамгаалах чиглэлээр баримтлах бодлого хөтөлбөр болон бусад холбогдох хууль тогтоомж, заавар, зөвлөгөөг сурталчлах.

Гурав. Сургууль, дадлага явуулах хугацаа

3.1. Гамшгаас хамгаалах “Иж бүрэн” сургуулийг Баянлиг, Хүрээмжарал суманд 2024 оны 10 дугаар сарын 21-31-ний өдрийн хооронд зохион байгуулна.

Дөрөв. Сургууль зохион байгуулах бүрэлдэхүүн

Сургуулийн удирдагч	1. Б.Мягмарсүрэн	Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа;
Дундын хянач	2. Ж.Батзолбоо	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад;
	3. Б.Буяндэлгэр	Ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч;
	4. Г.Энхбаяр	Онцгой байдлын газрын Эмч-сэтгэл зүйч, дэслэгч;
	5. Л.Ганбаяр	Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч;
	6. А.Гончигсумлаа	Зоонозын өвчин судлалын төвийн Нян судлагч эмч;
	7. Б.Мөнхнасан	Гал түймэр унтраах, аврах 16-р ангийн Аврагч, гал сөнөөгч, ахлах ахлагч;
	8. Б.Ундармаа	Улаанзагалмай хорооны Арга зүйч;
Нарийн бичиг	9. Г.Баярсайхан	Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч.
Жолооч	10. Э.Лувсанпэрэнлэй	Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах автомашины жолооч, ахлах ахлагч.

Тав. Сургуульд оролцох бүрэлдэхүүн

5.1. Баянлиг суманд:

- 5.1.1. Сумын гамшгаас хамгаалах орон тооны бус штаб-13;
- 5.1.2. Сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн-68;
- 5.1.3. Багийн Засаг дарга-5;
- 5.1.4. Багийн эмч нар-4;
- 5.1.5. Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, ажилтнууд-6;
- 5.1.6. Ард иргэд-3714;
- 5.1.7. Автомашин-6;

5.2. Хүрээмжарал суманд:

- 5.2.1. Сумын гамшгаас хамгаалах орон тооны бус штаб-19;

5.2.2.Сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн-51;

5.2.3.Багийн Засаг дарга-5;

5.2.4.Багийн эмч нар-4;

5.2.5.Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, ажилтнууд-7;

5.2.6.Ард иргэд-1817;

5.2.7.Тээврийн хэрэгсэл-5.

Зургаа.Сургуулийн бэлтгэл ажлыг хангуулах хүрээнд


6.1.Гамшгаас хамгаалах “Иж бүрэн”-ын сургуулийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд сумын Засаг дарга, гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн ангийн дарга нь дараах ажлыг хариуцан зохион байгуулсан байна. **Үүнд:**

- Бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх;
- Бүх шатны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох;
- Сургуулийн бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулалтын бусад арга хэмжээг авах чиглэлээр захирамж, тушаал, албан даалгавар гаргаж төр захиргааны болон мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд иргэдэд үүрэг, чиглэл өгөх;
- Сургуулийг зохион байгуулах зардлыг төсөвт тусгаж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байх;
- Холбоо, зарлан мэдээллийн техник, хэрэгслийн (дуут дохионы хамт тэмдэг, бичиг дуут мэдээлэл) бэлэн байдлыг хангах;
- Сургуульд оролцох бүрэлдэхүүний хувийн бэлтгэлийг хангуулж, бэлэн байдлын үүргэвчийг жигдрүүлэх;
- Сургуульд шаардлагатай техник, хэрэгслийг бэлтгэх;
- Шаардлагатай бичиг баримтуудыг боловсруулах;
- Удирдлагын хөдөлгөөнт болон суурин штабын байрыг бэлтгэх, төхөөрөмжлэх;
- Мэргэжлийн ангийн хүч хэрэгсэл тооцоо судалгаа гаргах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах;
- Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хүч хэрэгсэл дайчлах, нүүлгэн шилжүүлэх, тараан байрлуулах, аврах хор уршигийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хээрийн эмнэлэг дэлгэн ажиллуулах, жигдрэлтийн дадлага сургуулийг зохион байгуулах;
- Хөнөөлийн голомтыг дуурайлган үзүүлэх талбай, нэрвэгдэгсэд буюу орлон тоглогчид болон аврах багаж хэрэгслийг бэлэн болгох;
- Тухайн нутаг дэвсгэрийг байр зүйн болон план зургийг бэлтгэх;
- Бэлтгэл ажлын хүрээнд нийтийг хамарсан тухайн орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн бүтээлч ажил зохион байгуулах;

- Тухайн орон нутгийн сүүлийн 5-10 жилд тохиолдсон судалгааг гаргах;
- Сургуулийн үйл ажиллагаанд иргэд олон нийтийг татан оролцуулах, сурталчлах;
- “Иж бүрэн”-ын сургуулийн бэлтгэл ажлыг хангаж, хийж гүйцэтгэсэн ажлын тайланг бэлтгэж танилцуулах.

Долоо. Дүгнэлт

7.1. Аймгийн Онцгой байдлын газрын Урьдчилан сэргийлэх тасгаас боловсруулсан бодлого, төлөвлөгөөний дагуу удирдан явуулж ОБЕГ-ын даргын 2023 оны А/412 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар”-ын 5.2-т заасны дагуу үнэлгээ, дүгнэлт өгч аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулна.

ХЯНАСАН:
**ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ОРЛОГЧ,
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАСГИЙН ДАРГА
ДЭД ХУРАНДАА**  **Б.МЯГМАРСҮРЭН**

БОЛОВСРУУЛСАН:
**ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ,
БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ,
ХОШУУЧ**  **Г.БАЯРСАЙХАН**